

Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа (2025 оны II улирал)

Хураангуй:

“Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2025 оны 7 дугаар сард цуглуулж, 402 аж ахуйн нэгжийн хариултад үндэслэн судалгааны үр дүнг нэгтгэлээ.

- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй, хүнсний болон хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, барилга, дотоод худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, 10-аас дээш жил ажилласан туршлагатай, 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой байна.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол (Зураг 1.1):

Инфляцын хүлээлт	2025 оны III улиралд	2026 оны II улиралд
Дундаж хүлээлт	9.0%	9.8%
Медиан хүлээлт	9.8%	10.6%


Ирэх 3 сар болон ирэх 12 сарын хугацаанд эм, эмнэлгийн үйлчилгээ, холбоо шуудангийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ эрхэлдэг ААН-үүдийн хувьд бараа, үйлчилгээний үнэ 10 нэгж хувиас дээш өсөх хүлээлт давамгайлж байна.

- **Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт:** Ерөнхий салбаруудын хувьд дотоод худалдаа (+8.8) болон үйлчилгээний (+4.2) салбарын үзүүлэлт бага зэрэг өссөн бол барилга (-9.2), аж үйлдвэр (-2.5), хэрэглэгчдийн (-6.8) үзүүлэлт тус тус буурснаар эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас 0.4 нэгжээр буурч, тайлант улиралд **89.3**-тай агшилтын мужид хэвээр хадгалагдлаа.
- **Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт:** Ерөнхий салбаруудын хувьд аж үйлдвэрийн (+0.9) салбарын хүлээлт бага зэрэг өссөн бол барилга (-22.7), дотоод худалдаа (-17.8), үйлчилгээний (-18.7) салбарын ажил эрхлэлт тус тус буурснаар ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 14.4 нэгжээр буурч, тайлант улиралд **93.3**-тай агшилтын муж руу шилжлээ.
- **Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт:** Ерөнхий салбаруудын хувьд барилга (+21.7), үйлчилгээ (+12.3), дотоод худалдаа (+3.8), хэрэглэгчдийн (+7.0) тодорхой бус байдал өссөн бол аж үйлдвэрийн (-8.8) салбарын тодорхой бус байдал бага зэрэг буурснаар эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт өмнөх улирлаас 2.3 нэгжээр өсөж, тайлант улиралд **143.3**-тай тэлэлтийн мужид хэвээр хадгалагдлаа.


I. Аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс инфляц хэрхэн өөрчлөгдөх талаар асууж, чиглэлийн индексийг тооцоход ирэх 3 сар болон ирэх 12 сарын чиглэлийн индексийн утгууд өнгөрсөн улирлын түвшнээс өөрчлөлт багатай гарлаа. Ирэх 3 болон ирэх 12 сарын үнийн хүлээлтийн чиглэлийн индексийн утгын хувьд “Үнийн өсөлт өснө” мужид хэвээр гарлаа (Зураг 1.1).

Зураг 1.1: Инфляцын хүлээлтийн индекс, ирэх 3 болон 12 сарын хугацаанд




Зураг 1.2: Инфляцын хүлээлтийн, ирэх 3 болон 12 сарын хугацаанд




Ирэх хугацааны хүлээлтийн талаар ААН-үүдийн тоон хариултад үндэслэн инфляцын дундаж утгыг тооцоход 2025 оны III улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар буурч **9.0%**, 2026 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар буурч **9.8%**-тай тус тус гарлаа (Зураг 1.2). Харин инфляцын хүлээлтийн тоон хариултаас медиан утгыг тооцоход 2025 оны улирлын хүлээлт өмнөх улирлаас 1.1 нэгж хувиар буурч **9.8%**, 2026 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас 1.2 нэгж хувиар буурч **10.6%**-тай гарлаа (Зураг 1.3-Зураг 1.4). Мөн 2024 оны 6 сараас хойш гурван улирал дараалан нэмэгдээд байсан инфляцын хүлээлтийн утга тайлант улиралд бага зэрэг буурсан төлөвтэй гарлаа (Зураг 1.3-Зураг 1.4).

Зураг 1.3: Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан & дундаж утга, ирэх 3 сар




Зураг 1.4: Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан & дундаж утга, ирэх 12 сар



ААН-үүдийн борлуулалтын дийлэнх хувийг бүрдүүлдэг бараа, үйлчилгээний төрлүүдийг үндэслэн ХҮИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, худалдаалдаг болон үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдээр нь тус тус бүлэглэлээ. Уг бүлгээр инфляцын хүлээлтийн хариултыг харьцуулахад ирэх 3 сард дийлэнх аж ахуйн нэгжүүд (48%) үнийн өсөлт 10.0 нэгж хувиас их байх хүлээлт давамгайлж байна. Тухайлбал, боловсролын үйлчилгээ, эм эмнэлгийн үйлчилгээ, холбоо шуудангийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үнийн өсөлт 10.0 хувиас их байх хүлээлт давамгайлж байна (Зураг 1.5). Ирэх 12 сард дийлэнх аж ахуйн нэгжүүд (64%) үнийн өсөлт 10.0 нэгж хувиас их байх хүлээлттэй давамгайлж байна. Тухайлбал, Боловсролын үйлчилгээ, эм эмнэлгийн үйлчилгээ, холбоо шуудангийн үйлчилгээ, хувцас, хүнс, гэр ахуй, бусад бараа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үнийн өсөлт 10.0 хувиас их байх хүлээлт давамгайлж байна (Зураг 1.6).

Зураг 1.5: ААН-ийн ирэх 3 сарын инфляцын хүлээлт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/




Зураг 1.6: ААН-ийн ирэх 12 сарын инфляцын хүлээлт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/



Тоон хариултын интервал тус бүрийн дундаж утгыг жигнэн, инфляцын хүлээлтийн утгыг тооцвол инфляц ирэх 3 сарын хүлээлт өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар буурч **9.0%**, ирэх 12 сарын хүлээлт 0.6 нэгж хувиар буурч **9.8%**-тай байх хүлээлттэй байна (Зураг 1.7).

Зураг 1.7: ААН-ийн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тархалт, тоон хариулт




II. Бизнесийн үйл ажиллагааны төлөв


Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт ESI¹

Монгол Улсын эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас 0.4 нэгжээр буурч, 2025 оны II улиралд **89.3** утгатай гарлаа. Энэ нь өнгөрсөн улирлын утгатай ойролцоо бөгөөд агшилтын мужид хэвээр байна (Зураг 2.1). Ерөнхий салбаруудын индексийг харвал бүгд 100-аас доош, өөрөөр хэлбэл, агшилтын бүсэд байна (аж үйлдвэр 88.2, барилга 89.0, дотоод худалдаа 89.7, үйлчилгээ 87.1, хэрэглэгч 94.9). Энэхүү үзүүлэлтийг өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад дотоод худалдаа (+8.8), үйлчилгээ (+4.2) өсөлттэй гарсан бол, барилга (-9.2), хэрэглэгч (-6.8), аж үйлдвэр (-2.5) тайлант улиралд бууралттай гарлаа (Зураг 2.2).

Зураг 2.1: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт



Зураг 2.2: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт, салбараар



Тэмдэглэл: Энэхүү үзүүлэлт нь эдийн засагт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European business cycle indicators” тайлангийн аргачлалыг сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар жигнэн тооцсон болно.

Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European business cycle indicators” тайлангийн аргачлалыг сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар жигнэн тооцсон болно.

Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European business cycle indicators” тайлангийн аргачлалыг сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар жигнэн тооцсон болно.


Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European business cycle indicators” тайлангийн аргачлалыг сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар жигнэн тооцсон болно.

¹ Economic Sentiment Index


Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)²

Тайлант улиралд **93.8** утгатай буюу 100-аас доош гарсан нь ажиллагсдын тоо ирэх улиралд буурах хүлээлт давамгайлж байна. Үзүүлэлт өмнөх улирлаас 14.4 нэгжээр буурсан нь ажил эрхлэлтийн өсөлт буурах дохио болохыг илтгэж байна (Зураг 2.3). Ерөнхий салбарууд бүгд буурч агшилтын муж руу шилжлээ (барилга 98.5, дотоод худалдаа 94.1, үйлчилгээ 91.9, аж үйлдвэр 98.5). Тус үзүүлэлтийг өмнөх улирлын утгатай харьцуулахад барилга (-22.7), үйлчилгээ (-18.7), дотоод худалдаа (-17.8) буурсан бол, аж үйлдвэр (+0.9) тайлант улиралд өсөлттэй гарлаа (Зураг 2.4).

Зураг 2.3. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.4. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт, салбараар



Эдийн засгийн тодорхой бус байдал (EUI)³


Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлын талаар аж ахуйн нэгж, иргэдээс асууж, хүлээлтийн утгыг тооцоход 2025 оны II улиралд өмнөх улирлаас 2.8 нэгжээр өсөж, **143.3** утгатай гарлаа. Тус үзүүлэлт нь 100-с дээш утгатай байгаа нь эдийн засагт тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг илтгэж байна (Зураг 2.5). Мөн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт нэмэгдсэн байна. Тухайлбал, ОУВС-аас эрхлэн гаргадаг “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд гадаад худалдааны геополитикийн нөхцөл байдал болон худалдааны түнш орнуудын эдийн засгийн төлөвт тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Түүнчлэн, геополитикийн хурцадмал байдал болон гадаад худалдаанд чиглэсэн хамгаалах бодлогууд нь эдийн засгийн урт хугацааны өсөлт болон инфляцад сөргөөр нөлөөлж болзошгүй талаар тусгажээ.

Голлох салбаруудын хувьд авч үзвэл, эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт хэрэглэгчдэд хамгийн өндөр, харин барилгын салбарт харьцангуй бага (хэрэглэгч 162.6, аж үйлдвэр 138.9, үйлчилгээ 113.7, дотоод худалдаа 144.1, барилга 125.0) гарлаа. Тус үзүүлэлтүүдийг өмнөх улирлын утгатай харьцуулахад аж үйлдвэрийн утгаас бусад үзүүлэлтүүд өссөн (дотоод худалдаа +21.7, үйлчилгээ +12.3, хэрэглэгч +7.0, барилга +3.8, аж үйлдвэр -8.8) дүр зурагтай байна (Зураг 2.6).


² Employment Expectation Index

³ Economic Uncertainty Index

Зураг 2.5. Эдийн засгийн тодорхой бус байдал



Зураг 2.6. Эдийн засгийн тодорхой бус байдал, салбараар




Бусад үзүүлэлтүүд

Ирэх улирлын эрэлтийн хүлээлт өмнөх улирлаас 6.1 нэгжээр буурч, **99.6** утгатай буюу өөрчлөлтгүй төлөвтэй ойролцоо гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл барилга, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарын хүлээлт буурсан бол дотоод худалдааны салбарын хүлээлт бага зэрэг нэмэгдсэн байна (Зураг 2.7). Ирэх улирлын экспортын хүлээлт өмнөх улирлаас 5.1 нэгжээр буурч **92.5** утгатай гарч, агшилтын мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл дотоод худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарын хүлээлт буурсан байна (Зураг 2.8). Тодруулбал, эрэлтийн голлох салбарын хүлээлтүүд 86.8–130.2, экспортын голлох салбарын хүлээлтүүд 88.3–94.7 нэгжийн хооронд байна.


Ирэх улирлын зээлийн хүүний хүлээлт тайлант улиралд 12.5 нэгжээр буурч, **135.9** утгатай буюу зээлийн хүү өсөх мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл аж үйлдвэр, барилга болон дотоод худалдааны салбарын зээлийн хүүний хүлээлт буурсан байна (Зураг 2.9). Ирэх улирлын ханшийн хүлээлт өмнөх улирлаас 8.3 нэгжээр өсөж, **155.0** утгатай төгрөг сулрах мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл үйлчилгээ, дотоод худалдааны салбарт ханш сулрах хүлээлт нэмэгдэж, аж үйлдвэр болон барилгын салбарын ханш өсөх хүлээлт бага зэрэг буурсан байна (Зураг 2.10). Тодруулбал, зээлийн хүүний үзүүлэлтийн голлох салбарын хүлээлтүүд 118.9–151.2, ханшийн үзүүлэлтийн голлох салбарын хүлээлтүүд 138.9–169.1 нэгжийн хооронд байна.

Ирэх улирлын нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлт өмнөх улирлаас 13.8 нэгжээр буурч, **157.8** утгатай тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл дотоод худалдаа, аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын хүлээлтүүд буурсан байна (Зураг 2.11). Ирэх улирлын ажиллах хүчний зардлын хүлээлт өмнөх улирлаас 14.6 нэгжээр буурч, **141.9** утгатай тэлэлтийн мужид хэвээр гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл аж үйлдвэр, барилга, болон дотоод худалдааны салбарын хүлээлтүүд буурсан байна (Зураг 2.12). Тодруулбал, нэгж бүтээгдэхүүний зардлын үзүүлэлтийн голлох салбарын хүлээлтүүд 170.6–145.6, ажиллах хүчний үзүүлэлтийн голлох салбарын хүлээлтүүд 156.2–97.5 нэгжийн хооронд байна.

Зураг 2.7. Эрэлтийн хүлээлтийн үзүүлэлтийн үзүүлэлт




Зураг 2.8. Экспортын хүлээлтийн үзүүлэлт




Зураг 2.9. Зээлийн хүүний хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.10. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.11. Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.12. Ажиллах хүчний зардлын хүлээлтийн үзүүлэлт



III. Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ерөнхий мэдээлэл

Түүвэр судалгааг 2025 оны 6, 7 дугаар сард явуулж, нийт **402** аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан бөгөөд өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 385 (96%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 11 (3%) нь хувьцаат компани (ХК), үлдсэн 6 (1%) нь бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй ААН-үүд байна /Хүснэгт 1.1/.

Хувийн хэвшлийн ААН-үүд судалгаанд голлон хамрагдсан бөгөөд тэдгээрийн 42% нь 20-с дээш, 23% нь 15-20 жилийн, 17% нь 10-15 жилийн, 13% нь 5-10 жилийн бол 4% нь 5-с доош жилийн турш үйл ажиллагаа эрхэлсэн ААН-үүд байна /Хүснэгт 1.2/.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны 68 (17%), хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн 63 (16%), барилгын 68 (17%), хүнсний бус боловсруулах үйлдвэрлэлийн 34 (8%), уул уурхайн 18 (4%), үйлчилгээний 151 (37%) ААН-үүд судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.3/.

Жилийн борлуулалтын орлогоор авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 192 (48%), 1.0 тэрбум төгрөгөөс 2.5 тэрбум төгрөгийн орлоготой 66 (16%), 300 саяас 1.0 тэрбум төгрөгийн орлоготой 67 (17%), 50.0-300.0 сая төгрөгийн орлоготой 56 (14%), 50 сая төгрөгөөс доош орлоготой 21 (5%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1.4/.

Хүснэгт 1.1: Аж ахуйн нэгжийн тоо /өмчлөлөөр/

Өмчлөлийн хэлбэрийн ангилал	тоо	хувь
ХХК	385	96%
Хувьцаат компани	11	3%
Бусад	6	1%
НИЙТ ДҮН	402	100%

Хүснэгт 1.2: Аж ахуйн нэгжийн тоо /туришлага, жилээр/

Хугацааны ангилал	тоо	хувь
5 хүртэл	18	4%
5-10 хүртэл	54	13%
10-15 хүртэл	67	17%
15-20 хүртэл	94	23%
20-с дээш	169	42%
НИЙТ ДҮН	402	100%

Хүснэгт 1.3: Аж ахуйн нэгжийн тоо /салбараар/

Салбарын ангилал	тоо	хувь
Боловсруулах үйлдвэрлэл /хүнсний/	63	16%
Боловсруулах үйлдвэрлэл /хүнсний бус/	34	8%
Уул уурхай, олборлолт	18	4%
Барилга	68	17%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	68	17%
Үйлчилгээний	72	18%
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамж	21	5%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	9	2%
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	16	4%
Зочид буудал, байр, сууц болон хоол	14	3%
Мэдээлэл, холбоо	7	2%
Санхүүгийн болон даатгалын ү.а	8	2%
Боловсрол	4	1%
НИЙТ ДҮН	402	0%

Хүснэгт 1.4: Аж ахуйн нэгжийн тоо /орлогоор/

Орлогын ангилал	тоо	хувь
50 сая төгрөг хүртэл	21	5%
50-300 сая төгрөг хүртэл	56	14%
300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	67	17%
1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл	66	16%
2.5 тэрбум төгрөгөөс дээш	192	48%
НИЙТ ДҮН	402	100%

Жилийн борлуулалтын орлого болон ажилчдын тооны бүлгээр ангилбал 10 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой бичил ангилалд хамаарах 117 (29%), 10-аас 200 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой жижиг, дунд ангилалд хамаарах 93 (23%), 200-с дээш ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой том ангилалд хамаарах 192 (48%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.5/.

Хүснэгт 1.5: Аж ахуйн нэгжийн тоо /орлого, ажилтны тооны бүлгээр/

Борлуулалтын орлого	Ажилчдын тоо /бүлгээр/				Бүгд
	< 10	11–49	50–199	200= <	
50 сая төгрөг хүртэл	19	2	0	0	5%
50-300 сая төгрөг хүртэл	45	10	1	0	14%
300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	37	27	3	0	17%
1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл	16	44	6	0	16%
2.5 тэрбум төгрөгөөс дээш	10	74	74	34	48%
НИЙТ ДҮН	127	157	84	34	100%

IV. Хавсралт 2. Аргачлалын тайлбар

Эдийн засгийн мэдрэмжий үзүүлэлт (ESI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн болон хэрэглэгчдийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын аж ахуйн нэгж, хэрэглэгчдээс сонгогдсон асуултуудад өгсөн хариултуудын жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Аж үйлдвэр (жин 40%), үйлчилгээ (30%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), барилгын салбарууд (5%) хамаарна. Аж үйлдвэрийн салбараас тухайн улирлын **шинэ захиалга, бэлэн бүтээгдэхүүний нөөц**, ирэх улирлын **үйлдвэрлэл**, барилгын салбараас тухайн улирлын **шинэ захиалга**, ирэх улирлын **ажил эрхлэлт**, дотоод худалдааны салбараас тухайн улирлын **борлуулалтын орлого, худалдан борлуулах барааны нөөц**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, үйлчилгээний салбараас тухайн улирлын **бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал, шинэ захиалга**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, хэрэглэгчдээс тухайн улирлын **санхүүгийн байдал**, ирэх улирлын **санхүүгийн байдал, хэрэглээ** болон **эдийн засгийн нөхцөл байдал** зэрэг үзүүлэлтүүдийг асууж, асуулт тус бүрийн эерэг сөрөг хариултуудын нийт хариултад эзлэх хувийн зөрүүгээр тодорхойлсон болно.

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь судалгаанд хамрагдсан дөрвөн үндсэн салбарын аж ахуйн нэгжүүдийн хүлээлтийн жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 23%), барилга (8%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (18%), үйлчилгээний салбарууд (51%) хамаарна. ААН-үүдээс **ирэх улирлын ажил эрхлэлт** хүлээлтийн өөрчлөлтийг судалж, “Өснө”, “Буурна”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт (EUI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь аж ахуйн нэгжийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын өгсөн хариултуудын жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 40%), барилга (5%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), үйлчилгээний салбарууд (30%) хамаарна. ААН-үүдээс **өнгөрсөн улирлын тодорхой бус байдлын** талаарх өөрчлөлтийг судалж, “Өссөн”, “Буурсан”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Медиан утга (Symmetric Linear Interpolated Median)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо тоон асуулгын хариултаас Nicholas J. Cox (2009)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно. Хүлээлтийн утгыг тооцохдоо ХҮИ-д тулгуурлаж байгаа тул үнийн ерөнхий хандлагыг харуулна. Энэхүү тооцсон хүлээлтийн утга нь инфляцын утгыг шууд илэрхийлэхгүй болно